

## ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	3
1.1. Төслийн товч тодорхойлолт, хүчин чадал.....	7
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	9
2.1. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга .....	9
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	19
3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт .....	19
БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ .....	21
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУРУУЛАХ ХАМГААЛАА АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	22
БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	24
БҮЛЭГ 7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	25
БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	26
БҮЛЭГ 9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	27
БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	29
БҮЛЭГ 11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	30
БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	31

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Газрын гэрчилгээний 0000177213 дугаартай 15.0 га газрын булангийн цэгүүд..3	
Хүснэгт 2. Өмнөговь аймгийн Ханбогд сумын газрын сангийн ангилал .....	9
Хүснэгт 3. Ханбогд сумын уур амьсгалын олон жилийн дундаж үзүүлэлт .....	14
Хүснэгт 4. Төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл.....	19
Хүснэгт 5. 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал..21	
Хүснэгт 6. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ.....	22
Хүснэгт 7. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	24
Хүснэгт 8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	25
Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	26
Хүснэгт 10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	27
Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	29
Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	30
Хүснэгт 13. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө .....	31

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Засаг захиргааны зураг .....	4
Зураг 2. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг .....	5
Зураг 3. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг .....	6
Зураг 4. Төслийн төлөвлөлтийн зураг .....	7
Зураг 5. Төслийн талбайн фото зураг .....	8
Зураг 6. Төслийн талбайн районы д.т.д өндөршлийн зураг (метр).....	11
Зураг 7. Төслийн талбайн районы газрын гадаргын налуу (градус) .....	12
Зураг 8. Агаарын жилийн дундаж температур, жилийн нийлбэр хур тунадас.....	13
Зураг 9. Агаарын температур болон хур тунадасны олон жилийн хандлага .....	14
Зураг 10. Ханбогд сумын уур амьсгалын горим.....	15
Зураг 11. Ханбогд сумын харьцангуй чийгшил (2012, 2017, 2021 он).....	15
Зураг 12. Ханбогд сумын салхины хурд.....	16
Зураг 13. Ханбогд сумын салхины зүг чиглэлийн давтагдал.....	16

## БҮЛЭГ 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн нэр:** “Гаалийн хяналтын талбайн” төсөл.

**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:**

*Төсөл хэрэгжүүлэгчийн нэр*

- “Урд гурван сайхан” ХХК
  - Хувийн хэргийн дугаар:000500338
  - Регистрийн дугаар: 6400639

*Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, утас*

- Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, нийслэл хүрээ өргөн чөлөө, 320/6, 291 тоот
  - Утас: 976-88119638

*Компанийн хэлбэр*

- Хязгаарлагдмал хариуцлагатай компани

*Байгуулагдсан он*

- 2019.05.10

*Харьяалал*

- Монгол

**Төслийн байршил:**


“Урд гурван сайхан” ХХК-ийн төслийн талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын 5-р баг, Цагаанхад нэртэй газар байрлана.

- Талбайн хэмжээ: 15.0 га
- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: К-48-60


**Газарзүйн солбицол:**

*Хүснэгт 1. Газрын гэрчилгээний 0000177213 дугаартай 15.0 га газрын булангийн цэгүүд*


№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	107	30	10.1	42	37	27.5
2	107	30	4.6	42	37	33.6
3	107	30	7.3	42	37	36.5
4	107	30	7.0	42	37	36.8
5	107	30	25.4	42	37	45.7
6	107	30	31.5	42	37	38.7
7	107	30	13.1	42	37	29.9



Зураг 1. Засаг захиргааны зураг




Зураг 2. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг



Зураг 3. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг

### 1.1. Төслийн товч тодорхойлолт, хүчин чадал

Нүүрсний орд газраас 80-100 тонны даац бүхий авто тээврийн хэрэгслийг хүлээн авч нэг авто машины тэвшийг 30 минутад буулгана. Мөн ачилтын хугацаа ойролцоогоор 30 минут үргэлжилдэг ба өдөрт 50 автомашин нүүрс буулгаж, 50 орчим авто машинд ачих хүчин чадалтай. Талбайн нийт хүчин чадал нь жилдээ 2 сая тонн нүүрс шилжүүлэн ачих хүчин чадалтай. 41 хүнийг ажлын байраар хангах бөгөөд нийт ажилчдын 80 хувийг орон нутгаас хангана. Жилийн дөрвөн улирал үйл ажиллагаа явуулдаг.



Зураг 4. Төслийн төлөвлөлтийн зураг

Тус талбайн дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- ✚ Хяналтын бүсийн ажилчдын тосгон;
- ✚ Тээврийн машины зогсоол;
- ✚ Пүү-1;
- ✚ Нүүрс буулгах талбай;
- ✚ Пүү-2;
- ✚ Хяналтын камер;
- ✚ Тээврийн кемп.



Зураг 5. Төслийн талбайн фото зураг



## БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 2.1. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

**Газрын гадаргуу:** Өмнөговь аймгийн нийт нутаг дэвсгэр нь Алтайн өвөр говь, Галба-Ууш-Долоодын говь, Онги, Таац, Умардын говийн гүвээт Халхын голын гэсэн ай савуудад хамрагддаг байна. Аймгийн нутаг дэвсгэр ерөнхийдөө говь, цөлөрхөг хээр зонхилсон байх ба Говь Гурван Сайхан уулын Байгалийн нөөц газар, Загийн ус Байгалийн цогцолборт газар, Говийн бага (А, Б) Дархан цаазтай газар зэрэг улсын тусгай хамгаалалттай газрууд байна.

Аймгийн нутаг төв хэсэгтээ хамгийн өндөрлөг буюу далайн түвшнээс дээш 2800 м, бусад хэсэгтээ нам дор газар буюу д.т.д 1090 м орчим өндөрт өргөгдсөн байна. Монгол орон өргөргийн дагуу сунаж тогтсон, хойноосоо урагш чиглэлд байгалийн эрс тэс онцлог бүхий уулын тайга, өндөр уул, ойт хээр, нугат хээр, хээр, хуурай хээр, цөлжүү хээр, заримдаг цөл, умардын цөл, жинхэнэ цөл, говь цөл гэсэн бүс бүслүүрүүд оршдог.

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр хуурай хээр, цөлийн хээр, умардын цөл, заримдаг цөл, цөл, жинхэнэ цөл гэсэн бүс бүслүүрт хамрагдаж байна.

Хүснэгт 2. Өмнөговь аймгийн Ханбогд сумын газрын сангийн ангилал


№	Газар нутаг	Хэмжээ (га)
1	Тусгай хэрэгцээний газар	201666
2	Хөдөө аж ахуйн газар	1168547
3	Хот тосгон бусад суурин газар	3691.2
4	Дэд бүтцийн газар	7541
5	Ойн сангийн газар	132904
6	Усан сан бүхий газар	807

**Ханбогд сумын физик газарзүй:** Энэхүү судалгааны талбай нь Монгол орны байгалийн бүс бүслүүрийн, газарзүйн байршлын хувьд Монголын говь цөлийн бүсийн өмнөд хэсэгт байрладаг. Говь цөлийн бүс нь Монголын өмнөд, Хятадын хойд, баруун хойд хэсгээр үргэлжлэх ба Ази тивд орших хамгийн том цөлийн бүс юм. Хойд талаараа алтайн нуруу Монголын тал хээр нутаг, баруун өмнө талаараа Төвөдийн өндөрлөг, зүүн өмнө талаараа Хятадын тэгш өндөрлөгтэй залгана. Ханбогд сумын нутагт Ундайн говь, Байшин цав, Чингисийн уургын нүх, Хөдөлдөг цохио, Мэлхий хад, Гурван зээрдийн агуй, 3000 хайлаас, Сэвхүүлийн элс, Хаалганы рашаан, Галбын говь зэрэг байгалийн үзэсгэлэн бүрдсэн 1515.2 кв.км нутаг дэвсгэртэй. Тус сум нь үнэмлэхүй байрлалын хувьд Говь-Алтайн нурууны өмнөд хэсэгт оршдог. Сумын төв цэг нь 43°11'46, 68"107°11'56.13"солбицолд оршино. Сумын төв нь далайн төвшнөөс дээш 1114 м өндөрт, солбицолд байрладаг.


Тус сум нь харьцангуй байрлалын хувьд урд талаараа БНХАУ-тай, баруун, хойд талаараа өөрийн аймгийн Манлай, Цогтцэций, Баян-овоо сумдтай, зүүн талаараа Дорноговь аймгийн Хатанбулаг, Мандах сумдтай хил залган оршдог. Улаанбаатар хотоос 650 км, аймгийн төв Даланзадгад хотоос 250 км алслагдсан Монгол улсын өмнөд хилээс 130 км, аймгийн төвөөс 252 км алслагдсан бөгөөд өмнө талаараа БНХАУ-тай, баруун талаараа Баян-Овоо, хойд талаараа Манлай, Цогтцэций, зүүн талаараа Дорноговь аймгийн Хатанбулаг сумтай хил залгана. Сумын нутаг дэвсгэрт Ханбогд, Жавхлант, Алаг баян,

Сангастай, Хоёр хасар, Галба, Гавиулуут зэрэг өндөрлөг бэсрэг уул нуруудтай, 100-130 км үргэлжилсэн Галбын говь, Дайчингийн говь, Сэвхүүлийн хоолойн элсэн далан, заган шугуй, Уртын гол, Ундайн гол, Халзан хайлаастын гол гэх зэрэг хайлаасан зурвасуудтай, янз бүрийн хэлбэр дүрс бүхий боржин чулуун цохиотой. Тогоо, Гурван зээрд, Ухаа агуйнууд зэрэг байгалийн өвөрмөц тогтоц бүхий газруудтай.

**Физик газарзүйн мужлал:** Тус судалгааны талбай нь Говийн их мужийн Дорнод говийн дэд мужид хамаарна. Дорнод говийн дэд муж нь говийн их мужийн зүүн хагасыг эзэлж, баруун талдаа Говь Алтайн Хурх, Гурван Богдын нурууд, хойд ба зүүн хойд талдаа Монголын Дорнод талаар хүрээлэгдэн урд талын хил улсын хилтэй нийлнэ. Гадаргын зохион байгуулалтын талаар Дорнод говь, Алтайн өмнөх болон ар говиос ялгаатай, харин Монголын дорнод талтай төстэй гэж болно. Учир нь ухаа гүвээт тал ихэнх нутгийг эзэлнэ. Маш налуу хажуутай, ил гарсан хад чулуу бараг байхгүй ухаа, гүвээний хооронд их бага янз бүрийн хэмжээтэй хотос, тал газар байх бөгөөд түүнд хужир, марз цөөнгүй тогтоно.



Зураг 6. Төслийн талбайн районы д.т.д өндөршлийн зураг (метр)




Зураг 7. Төслийн талбайн районы газрын гадаргын налуу (градус)

**Өмнөговь аймгийн уур амьсгалын горим:** Нутаг дэвсгэрийн хэмжээ нь 165.4 мян км<sup>2</sup> бөгөөд хамгийн баруун цэгээс зүүн цэг хүртэл 700 км, хамгийн хойд цэгээс урд цэг хүртэл 400 км орчим зайтай. Өмнөд хэсгээрээ БНХАУ-тай, хойд хэсгээрээ Өвөрхангай, Дундговь аймгийн нутаг, зүүн хэсгээрээ Дорноговь аймгийн нутаг харин баруун хэсгээрээ Ханбогд хонгор аймгийн нутагтай хил залгаа оршдог.

Нутаг дэвсгэрийн хувьд хайрга чулуу элс ихтэй тачир сийрэг бэлчээрийн ургамалтай, уул нуруу, хонхор хөндий, тэгш тал, говь цөл алаглан оршдог. Эх газрын хуурай сэрүүн, эрс тэс уур амьсгалтай, өргөргийн дагуу буюу баруун талын уулархаг нутгаасаа зүүн тийш говь уруугаа болох тусам дулаардаг хуурай агаартай хөрснөөс уурших чийгийн нөөц бага, агаар нэн хуурай учраас хур тунадасны хэмжээ бага, салхи ихтэй учир шороон шуургатай өдрийн тоо олон байдаг. Энэ онцлогоороо хөрсний физик өгөршүүлэл ихтэй, тариалан эрхлэхэд тохиромжгүй байдаг ч нар салхины эрчим хүчний их нөөцтэй нутаг юм.


Монгол оронд агаарын жилийн дундаж температур, нийлбэр хур тунадасны газарзүйн хуваарилалт нутаг дэвсгэрийн янз бүрийн хэсэгт харилцан адилгүй. Зураг 8-д Цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан Монгол орны жилийн агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны нормын (1991-2020 оны) тархалтын мэдээллийг Өмнөговь аймгийн хэмжээнд таслан үзүүлэв.



Зураг 8. Агаарын жилийн дундаж температур, жилийн нийлбэр хур тунадас (Эх сурвалж: [www.irimhe.namem.gov.mn/](http://www.irimhe.namem.gov.mn/))

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд олон жилийн дундаж агаарын температур нутгийн хойд хэсгээр +4...+6°C, төвийн уулархаг хэсгээр +2...+4°C мөн нутгийн өмнө хэсгээр +6°C-ээс дээш температуртай байна. Харин жилийн нийлбэр хур тунадас нутгийн ихэнх талбайд 50...150 мм орчим байх бөгөөд говь гурван сайхан орчим 150...200 мм унадаг байна.

Өмнөговь аймгийн уур амьсгалын ерөнхий хандлагыг “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан”-гийн 2005-2021 оны буюу 16 жилийн мэдээг ашиглан боловсруулав.



Зураг 9. Агаарын температур болон хур тунадасны олон жилийн хандлага

2005-2021 оны олон жилийн явцаас харахад агаарын дундаж температур ойролцоогоор 0.5°C-аар дулаарсан бөгөөд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор сүүлийн жилүүдийн (2012 оноос) ерөнхий хандлага нэмэгдсэн нь Зураг 10-т харагдаж байна. Энэ хугацаанд хамгийн хүйтэн жил 2009 онд +4.5°C, хамгийн дулаан жил 2018 онд +6.7°C хүрч байжээ. Харин хур тунадасны олон жилийн өөрчлөлтөөс үзвэл өссөн хандлагатай бөгөөд жилийн нийлбэр хур тунадасны хэмжээ 50...242 мм-ийн хооронд хэлбэлзсэн байна.


**Ханбогд сумын уур амьсгалын горим:** Ханбогд сумын уур амьсгалын олон жилийн дундаж үзүүлэлтийг Монгол улсын “Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн” Дэлхийн цаг уурын байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу Ханбогд цаг уурын станцын (ДТД-1109 м) 1991-2020 оны агаарын температур, хур тунадасны стандарт нормыг цаг хугацааны сарын алхамтай тооцоолсон мэдээг ашиглав.

Хүснэгт 3. Ханбогд сумын уур амьсгалын олон жилийн дундаж үзүүлэлт

Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Сарын дундаж агаарын температурын үзүүлэлтүүд													
Дундаж	-11.4	-7	0.7	9.8	16.9	22.7	25.4	23.2	17.2	8.2	-1.8	-9.3	7.9
Үнэмлэх их температур	12.7	15.6	24.3	33	36.5	40.5	42.2	39	35.2	31.1	18.8	11.9	42.2
Үнэмлэх бага температур	-31.1	-28.6	-22.1	-12.9	-6	4.7	10.1	7.2	-3.1	-13.5	-23.1	-28	-31.1
Сарын нийлбэр хур тунадасны үзүүлэлтүүд													
Нийлбэр	1.1	1.3	3.4	3.3	10.4	19.1	26.9	27.2	10.1	3.7	1.7	1	109.2
Хамгийн их	4.1	3.7	13.1	13.5	47.7	22.8	39.7	30.7	20.6	13.4	6.8	3.8	47.7

Энэхүү мэдээлэл нь цаг уурын байгууллагаас гарч байгаа мэдээ мэдээллийн ерөнхий суурь нөхцөл болохоос гадна газар тариалан, харилцаа холбоо, барилга байгууламж, авто зам, ачаа тээвэр, эрчим хүч, хот төлөвлөлт зэрэг олон салбаруудын техникийн баримт бичгийн стандарт норм, дүрэм болж ашиглагдах зориулалттай.


Ханбогд сумын уур амьсгалыг тодорхойлохдоо “Цаг уур, орчны шинжилгээний газар, Байгаль орчин, ус цаг уурын мэдээллийн төв архив”-аас Ханбогд станцын сүүлийн 10 жилийн (2012-2021 он) агаарын температур, хур тунадас болон салхины мэдээ, материалыг ашиглав.



Зураг 10. Ханбогд сумын уур амьсгалын горим

Ханбогд сумын нутагт 2012-2021 оны хооронд дунджаар агаарын температур +6.6...+8.9°C-ын хооронд хэлбэлзсэн бөгөөд өвлийн улиралд -10.6...-7.1°C, хаврын улиралд +2.6...+17.3°C, зуны улиралд +22.6...+25.6°C харин намрын улиралд -1.7...+17.5°C хүрсэн байна. Тухайн бүс нутагт жилд орох хур тунадасны нийлбэр 74.1...202.0 мм-ийн хооронд хэлбэлзэх бөгөөд өвлийн улиралд 0.5...2.4 мм, хаврын улиралд 2.4...8.5 мм, зуны улиралд 20.4...41.9 мм, намрын улиралд 1.6...12.8 мм-ын хооронд унадаг. Энэ бүс нутагт хамгийн их хур тунадас 7 сард дунджаар 41.9 мм, хамгийн бага хур тунадас 12 сард дунджаар 0.5 мм орчим унадаг байна.


Харьцангуй чийг нь тухайн агаар чийгээр ханахад шаардагдах чийгийн хэмжээний хэдэн хувийг эзэлж байгааг илэрхийлнэ. Энэ нь судалгааны талбайн уур амьсгалын чийглэг хуурай болохын шинж төлөвийг илэрхийлэх маш чухал үзүүлэлт бөгөөд уур амьсгалын судалгаанд өргөн ашигладаг. Зураг 11-д Ханбогд сумын агаарын харьцангуй чийгшлийн жилийн явцыг 2012, 2017 ба 2021 оноор болон 2012-2021 оны дундаж утгаар үзүүлэв.



Зураг 11. Ханбогд сумын харьцангуй чийгшил (2012, 2017, 2021 он)


Харьцангуй чийгшлийн жилийн явцын хамгийн их утга нь өвлийн улиралд 45 %, дараагийнх нь зуны улиралд 40 % хүрч тус тус ажиглагдана. Харин хамгийн бага их утга нь хаврын улиралд 24 %, дараагийнх нь намрын улиралд 34 % хүрч тус тус тохиолдоно. Эндээс үзвэл өвлийн хахир хүйтэн үе болон зуны хур тунадасны хэмжээнээс шалтгаалан агаарын чийгшил нэмэгддэг бол хавар, намрын улиралд дулааны өсөлт түргэн бөгөөд хөрсний нөөц чийг дутмаг байх учир агаар ихээхэн хуурай болдог нь харагдана.

Гадаргын онцлог, агаарын массын улирлын шилжилт циклон ба эсрэг циклоны солигдох байдал зэргээс үүдэн Монгол оронд салхи ихтэй байдаг. Салхины горимын үндсэн үзүүлэлт болох салхины чиглэл ба хурд нутаг бүрд харилцан адилгүй байдаг.



Зураг 12. Ханбогод сумын салхины хурд

Судалгаанд хамрагдаж буй нутагт салхины хурд жилд дунджаар 4.2 м/с байсан бөгөөд хавар, намрын улиралд өсөж өвөл, зуны улиралд буурсан байна. Салхины хурдны хамгийн их утга нь дунджаар 5 сард 5.9 м/с, хамгийн бага утга нь дунджаар 2 сард 2.1 м/с ажиглагдсан. Салхины зүг чиглэлийн давтагдал нь тухайн орон нутгийн физик газарзүйн тогтолцооны нөлөөлөлтэй. Салхины зонхилох зүг чиглэлийн давтагдлыг хувиар илэрхийлэн 4 улирлаар (Өвөл, хавар, зун, намар) 13-р зурагт үзүүлэв.



Зураг 13. Ханбогод сумын салхины зүг чиглэлийн давтагдал

Зургаас харахад салхины чиглэлийн давтагдал жилийн 4 улирлын туршид 12-26 % нь баруун өмнөд зүгээс, 10-24 % нь баруун зүгээс зонхилно.



**Ус зүй:** Төслийн талбайн район нь ус зүйн хувьд Төв Азийн гадагш урсацгүй ай сав, Галба-Өөш-Долоодын говийн сав газарт хамаарна. Энэхүү сав газар нь Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн 33.13 %-ийг хамарна.

Гол мөрний олон жилийн дундаж урсцын модуль нэн бага буюу 1 км<sup>2</sup>-аас бага (түр урсгал бүхий гол горхины мужид багтдаг), олон жилийн дундаж урсцын давхраа 25-ээс бага 1 хувийн хангамж бүхий шар ус, хур борооны үерийн хамгийн их урсцын модуль тус тус 0.1 м<sup>3</sup>/км-ээс бага (түр урсгал бүхий гол горхины муж) байна. Сумын нутагт тогтмол урсацтай томоохон гол мөрөн байхгүй.

Ханбогд сум нь ус зүйн хувьд Галба-Өөш-Долоодын говь голын сав газарт хамаарагддаг. Энэхүү сав газар нь Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн 33.13 %-ийг хамарна.

Сумын хэмжээнд 61 худаг, өрөмдмөл 5, богино яндант 5, энгийн худаг 51 рашаан булаг 44 байна. Тухайн сумын хэмжээнд 67 голын эх үүсвэртэй байна. Үүнээс 69.0 хувь нь гүехэн гар худаг, 80.0 хувь нь 2 м хүрэхгүй гүнтэй, 21.0 хувь нь гүний худаг, 85.0 хувь нь цоожтой. Устай 22 булаг, ус багатай 14, ширгэсэн 20 гаруй булаг байна. Ханбогд сумын хойд болон өмнөд талаар орших Хараат уул, Гурван хараат уул, Ханбогд зэрэг уулуудаас орж ирэх түр зуурын урсгал усны голдирлуудаар зун намрын эрчимтэй орсон борооны үед гадаргын урсац орж ирж жижиг тойрмуудыг үүсгэдэг. Харганатын хоолой, Шунхтын хоолой, Халивын хөндий, Таван модны хөндий, Галбын говь зэрэг томоохон хөндийгөөр хур борооны дараа түр зуурын урсац үүсэж, зарим үед гол хэлбэртэй тодорхой хугацаанд урсдаг. Ийм голуудын тоонд Харганатын гол, Ухаа загийн гол, Баян сухайн гол, Бага булгийн, Их булгийн голууд орно. Ханбогд болон Шавагтай, Халзан овоо, Алаг баян зэрэг уулсаас хур тунадас ихтэй жилүүдэд уулын тодорхой талбайд ус цугларан түр зуурын булаг үүсэж, тодорхой хугацаанд урсац үүсгэдэг. Ийм булгийн тоонд Ханбогд уулаас хойш чиглэж урсдаг Их, Бага булаг, Баяны задгай, Ухаа загийн булаг зэргийг нэрлэж болно. Эдгээрээс хамгийн том нь сумын төвийн урд талаар урсдаг Их булаг бөгөөд түүний урсцын хэмжээ нь дунджаар 1.3-6 л/с, урсцын өргөн 0.4-1 м хүрдэг. Бага булгийн хувьд Ханбогд сумын төвийн баруун талд түүнээс 12 км зайтай, дээд хэсэгт нь 35 м голчтой жижиг нуур байдаг бөгөөд энэ нь хур бороо орсны дараа тэр орчмын усаа цуглуулан хамгийн гүн газартаа 5 м хүртэл гүнтэй болдог. Ус нь харьцангуй цэнгэг, зөөлөн бөгөөд ихээхэн гантай жилээс бусад жилүүдэд байнга шахам байдаг. Энэхүү нуурын түвшин нь ихсэхээр түүнээс Бага булаг эх аван тухайн орчны түр зуурын урсцыг нэгтгэдэг.

**Хөрсөн бүрхэвч:** Хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэн төслийн талбайд бүхэлдээ цөлийн бор саарал хөрс тархсан байна. Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь шүлтлэг-хүчиллэг урвалын орчинтой, ялмагийн агууламж маш бага, цахилгаан дамжуулах чанар болон давсны агууламж маш бага буюу давсжилтгүй, карбонатгүй, шингээгдсэн сууриудын нийлбэр хэмжээ дунд зэрэг, хөдөлгөөнт фосфорын хангамж бага, калийн хангамж дунд зэрэг байна. Хүнд металлаар бохирдоогүй байна.

**Ургамлын нөмрөг:** Төслийн талбайн район нь Монгол орны байгалийн мужлалаар цөлөрхөг хээрийн (жинхэнэ цөлийн) бүсэд багтана. Ургамал газарзүйн мужлалаар Иран тураны муж, Умард говийн цөлөрхөг хээрийн провинци, Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт тус тус багтана.

Төслийн талбайн районд бүхэлдээ бор бударгана-баглуурт бүлгэмдэл тархсан байна. *Stipa gobica*, *Salsola passerina* зонхилно. Заримдаг сөөгөнцрөөс *Anabasis brevifolia*, *Artemisia caespitosa*, *Chenopodium frutescens*, *Kochia prostrata*, *Reaumuria soongorica* давамгайлна. Ургамлан нөмрөг техникийн нөлөөнөөс болж 80-90% нь утсан байна. Ургамлын тусгаг бүрхэц 10%, халцгай газрын хэмжээ 90% байна. 10 м<sup>2</sup> талбайд зүйлийн бүрэлдэхүүний тоо 5ш. Ургамлын ургац 0.1 ц/га байна.

**Ан амьтан:** Төслийн талбай нь Монгол орны говийн их мужид, геоморфологийн хувьд Дорнод говийн хойд хэсгийн тойрогт, Говийн дэд мужид багтдаг. Тус мужид нийтдээ 4 ангийн 172 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 26.4 % нь оршин амьдардаг байна.

Төслийн талбай орчимд янз бүрийн амьтан, ялангуяа хөрсөнд амьдрагч амьтад амьдрахад тохиромжтой нутаг юм. Амьтны аймгийн бүрэлдэхүүний үндсэн хэсгийг нь говь цөлийн бүсийн амьтад бүрдүүлж байна. Нийт 378 зүйл амьтан бүртгэгдсэнээс Монгол улсын улаан номд орсон 19 зүйл, ховор болон ховордсон амьтан, ургамлыг олон улсын хэмжээнд худалдаалах конвенцод орсон 12 зүйл амьтан байна. Мөн 1963 оноос хойш шинжлэх ухаанд шинээр нээгдсэн 90 зүйл сээр нуруугүйтэн байна.

Төслийн талбайн мужид жижиг хөхтөн, сээр нуруугүйтэйн амьтад зарим зүйл шувуу дийлэнхдээ тархсан байна.

**Хүн ам, эдийн засаг, зам харилцаа:** Тус сум нь 1924 онд Галба нэртэйгээр байгуулагдсан бөгөөд 1931 оноос Ханбогд нэртэйгээр өргөжин хөгжиж байна. Номгон, Хайрхан, Жавхлант, Гавилууд, Баян гэсэн 5 багийн нийт 2031 өрхтэй. 2021 оны байдлаар Ханбогд суманд оршин суугаа нийт 8404 хүн, Номгон багт 1201, Гавилууд 1866, Жавхлант 2637, Хайрхан 509, Баян 2191 хүн амьдарч байна.

Сумын хэмжээнд 2023 оны байдлаар 8404 хүн амьдарч байна. Өмнөх оныхтой харьцуулахад 0.2 %-аар өссөн үзүүлэлттэй байна. Сумын хэмжээнд нийт 114 аж ахуйн нэгж байгууллага бизнесийн үйл ажиллагаа явуулж улс орон нутгийн төсөвт бодит хувь нэмрээ оруулж байна. Ажиллах хүч салбараар ангилбал уул уурхайн салбарт 672 хүн, хөдөө аж ахуйн салбарт 580 хүн, үйлчилгээний салбарт 335 хүн ажилладаг.

Сумын газар нутаг дээгүүр Тавантолгой Гацуун сухайт чиглэлийн нүүрс тээврийн зам дайрч өнгөрдөг. Мөн Оюутолгой Ханбогд Манлай чиглэлийн 200 орчим км сайжруулсан шороон замтай. Аймгийн төв болон бусад сумдуут, багуудтай шороон замаар холбогддог. Сумын хэмжээнд инженерийн бүрэн хангамжгүй 1966 онд баригдсан 11 орон сууц байгаа юм. Одоогоор дээрх орон сууцуудын 8 нь хувьчлагдсан үлдсэн гуравт нь төрийн албан хаагчид амьдарч байна. Суманд сүүлийн жилүүдэд инженерийн бүрэн хангамжтай орон сууц баригдаагүй. Ханбогд сум нь цахилгааны хэрэгцээгээ 1600 квт хүчин чадалтай дизель цахилгаан үүсгүүрээр хангаж байна. Оюутолгой төслийн талбайтай 35 квт-ын ЦДАШ-аар холбогдсон. Эрчим хүчний эх үүсвэрийн хувьд одоогоор Оюутолгойн уурхайгаар дамжуулан БНХАУ-аас авахаар барилгын ажил явагдаж байгаа бөгөөд цаашдаа Монгол Улсын нэгдсэн шугам сүлжээнд холбогдох боломжтой. Сумын хэмжээнд 61-н хувийн гүний худаг ажиллаж байна. Бүх усыг зөөврийн байдлаар ашигладаг. Хувийн худагтай айл өрхүүд өөрийн хэрэгцээнд тохирсон усан хангамжийн сүлжээтэй. Нийтийн төвлөрсөн усан хангамжийн сүлжээ байхгүй.

### БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

#### 3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 4. Төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөөр	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцаггүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
<b>1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт</b>										
Газрын доорх урсцын өөрчлөлт			x							
Гадаргын урсцын өөрчлөлт			x							
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x					x
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x					x
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт			x							
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			x							
<b>2. Байгалийн нөөц ашиглалт</b>										
Газрын гадаргын нөөц баялаг			x							
Бэлчээрийн байдал			x							
Эрдэс түүхий эдийн нөөц			x							
Эрчим хүчний нөөц			x							
<b>3. Байгаль, орчны өөрчлөлт</b>										
Газрын доорх усны чанар, хэмжээ			x							
Гадаргын усны чанар хэмжээ			x							
Агаарын бохирдол			x							
Хөрсний бохирдол			x							
Төслийн үйл ажиллагаанаас ялгарах бохирдуулагч бодис хүний эрүүл мэндэд нөлөөлөх			x							
Дуу чимээ, шуугианы нөлөө			x							
<b>4. Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор</b>										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх			x							
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх			x							
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх			x							
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх			x							
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх			x							
<b>5. Нийгэмд үзүүлэх нөлөө</b>										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх		x			x				+	
Үйлчилгээний салбарын ү/а-нд нөлөөлөх		x			x					+
Хүн амын орлого өөрчлөгдөж, нэмэгдэх		x			x				+	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх			x							
<b>6. Эдийн засагт үзүүлэх нөлөө</b>										

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөөр	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
Татварын орлого өөрчлөгдөх	х				х		х			+
Орон нутгийн орлого нэмэгдэх	х				х		х			+
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	х				х		х			+
Ажлын байр нэмэгдэх	х				х		х			+
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	х				х		х			+
<b>7. Бусад нөлөөлөл</b>										
Бохир ус хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын усыг бохирдуулах			х							
Дүн	7	3	21	0	10	0	5	0	2	8
Дүн	7	3	21	0	10	0	5	0	2	8

Төслийн болзошгүй сөрөг болон эерэг нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчмийн үндэслэлийг дараах байдлаар гаргасан болно. Үүнд:

*Шууд нөлөөлөл:*

- Төслийн барилга байгууламжийн нөлөөгөөр биет хэмжээгээр хөрс, ургамлан бүрхэвч үүсмэл хэлбэршлээр солигдож, шууд, урт хугацаанд сөрөг нөлөөлнө;
- Дэд бүтцийн хөгжилд эергээр, урт хугацаагаар нөлөөлнө;
- Орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэгт төслийн үйл ажиллагаа явагдах хугацаанд болон цаашид эергээр нөлөөлнө.

*Шууд бус нөлөөлөл:*

- Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд урт хугацаанд эерэг нөлөөлнө.

*Хүчтэй нөлөөлөл:*

- Болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийх явцад төслийн зүгээс хүчтэй нөлөөлөх нөлөө байхгүй байна.

#### БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах “Урд гурван сайхан” ХХК-ийн “Гаалийн хяналтын талбайн” төслийн БОМТ-г БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 1-р хавсралтыг баримтлан боловсруулсан болно.

*Зорилго:* Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

*Гол зорилтууд:*

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;
- Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх.

*Хүснэгт 5. 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал*

№	Ажлын нэр	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	7,500.0
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	7,455.0
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	3,200.0
5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,700.0
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	981.0
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	8,800.0
8	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
<b>Нийт дүн</b>		<b>30,636.0</b>

**БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУРУУЛАХ ХАМГААЛАА АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

*Хүснэгт 6. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ*

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт	
<b>Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ</b>										
1	Авто тээврийн хэрэгслээс тоосжилт, хорт хий ялгарах	Тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд жил бүр тогтмол хамруулах.	Агаар орчин	тогтмол		Үйл ажиллагааны зардал		2024 он	Агаарын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль MNS 4585:2016	
2		Мэдээллийн самбарт анхааруулга тавих	Агаар орчин	удаа	1	-	300.0	2024 он		
3		Салхинаас хамгаалсан төмөр хашааг засварлах	Агаар орчин	удаа	1	5,000.0	5,000.0	2024 он		
<b>Дүн</b>							<b>5,300.0</b>			
<b>Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ</b>										
4	Усан орчин бохирдох,	Ажлын байранд ариутгал халдваргүйжтэл хийх зөвлөмж	Эрүүл ахуй	Улиралд 1 удаа	20	Үйл ажиллагааны зардал		2024 он	“Усны тухай хууль” Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль NS 6561:2015 MNS 4943:2015 MNS 6734:2018 “Усны тухай хууль” “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам” Усны тухай хууль Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль БОАЖЯ-ны сайд, ЭМ-ын сайдын хамтарсан тушаал-А/82/128 тоот журам	
5		Борооны ус хуримтлуулан дахин ашиглах зөвлөмж	Ус хэмнэх	ширхэг	Тогтмол	Үйл ажиллагааны зардал		2024 он		
6		Харьяалагдах сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр төлөх	Хаягдал бохир усны цооног	удаа	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардал		2024 он		
7	Усны нөөц хомсдох	Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөж ажиллах	Төслийн талбай	удаа		Үйлд ажиллагааны зардал		2024 он		
8	Усны чанар	70-80 хувь дүүрсэн үед бохирын цооногийг суллаж, цэг болон цэгийн орчинд халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр халдваргүйжүүлэлтийг хийлгэнэ.	Төслийн талбай	Тухай бүр		Үйлд ажиллагааны зардал		2024 он		
<b>Дүн</b>							<b>-</b>			
<b>Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ</b>										
9	Хөрсний бохирдол	Зориулалтын цэгээс гадагш элдэв хог хаягдал хаяхгүй, газрын төрх, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг	Төслийн талбай	удаа		Үйл ажиллагааны зардал		2024 он	MNS 5850:2019, “Хөрсний чанар, хөрсөнд агуулагдах	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
10		хэвшүүлэх							бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 3297:2019, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх”
		Хөрсөн орчны мониторинг судалгааг хийх	Төслийн талбайн хөрс	удаа	Улиралд 1 удаа		Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан	2024 он	
11		Төлөвлөлтийн дагуу цаашид барилга байгууламж баригдахгүй болон үйл ажиллагаанд өртөөгүй талбайг доройтуулахгүйгээр хамгаалж, хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдолт үүсэхээс урьдчилан сэргийлэх	Төслийн талбайд	удаа		Үйл ажиллагааны зардал		2024 он	
<b>Дүн</b>							-		
Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
12	Ургамал	Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж Өмнөговь аймгийн Ханбогд суманд 2500 мод тарих	Ханбогд сум	Жилд нэг удаа	500	-	2,000.0	2024 он	Нөхөн сэргээлтийн аргачлал Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай MNS 4585:2016
<b>Дүн</b>							<b>2,000.0</b>		
Бусад									
13	Цахилгаан эрчим хүчний хэрэглээ	Сэргээгдэх эрчим хүчийг илүүтэй сонгож хэрэглэх	Төслийн талбай	Иж бүрэн		Үйл ажиллагааны зардал		2024 он	Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль
14		Цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийг сонгож хэрэглэх	Төслийн талбай	Иж бүрэн		Үйл ажиллагааны зардал		2024 он	
15		Ариун цэврийн газар нь агааржуулагч сэнстэй байна.	Ариун цэврийн өрөө	Иж бүрэн		Үйл ажиллагааны зардал		2024 он	
<b>Дүн</b>							-		
<b>Нийт дүн</b>								<b>7,500.0</b>	

**БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

“Газрын тухай хууль”-ийн 56.6-р зүйл: Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байна.

*Хүснэгт 7. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө*

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг /мян/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ногоон байгууламж бий болгох	Мод тарих	Төслийн талбайн хэмжээнд	Ширхэг	1000	2,500.0	2024 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль MNS 4585:2016 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260 : 2011
		Зүлэгжүүлэх		м <sup>3</sup>	200	350.0	2024 он	
2	Хөрс бэлтгэх Нүх бэлтгэх	/Хар шороо, элс, бууц зэргийг бэлтгэнэ/	Ажилчны хөлс	Ажилчин	2	4,605.0	2024 он	
<b>Нийт дүн</b>						<b>7,455.0</b>		



### БҮЛЭГ 7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор төсөл хэрэгжүүлэгч нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах Монгол улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх;
- Төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-ын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэг хүлээн ажиллана.

Хүснэгт 8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологийн дурсгал	Хэрэв үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирвэл төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.	Төслийн талбай	-	Зардал тооцох боломжгүй	Зардал тооцох боломжгүй	2024 он	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/, Бусад холбогдох салбарын яамнаас гаргасан дүрэм журмууд
2	Палеонтологийн дурсгал							
<b>Нийт дүн</b>						-		

**БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

*Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө*

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын цэгийг тохижуулах	Хог хаягдлын цэг	Иж бүрэн	1 удаа	2,000.0	2,000.0	2024 он	БОАЖ-ын сайдын А/433 тогтоол Хог хаягдлын тухай хууль
2	Эзэмшил газрын ил задгай хаягдсан хогийг ангилан ялгаж цэвэрлэж байх	Төвийн ойр орчмын 100 метрт	Тогтмол	Үйл ажиллагааны зардал		2024 он		
3	Төслийн талбайд хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савыг байрлуулах, хаягжуулах	Төслийн талбайд	Иж бүрэн	Үйл ажиллагааны зардал		2024 он		
4	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Дахин ашиглагдах хог хаягдал	Тогтмол	Үйл ажиллагааны зардал		2024 он		
5	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх	Хог хаягдлын цэгт	Тогтмол	Улиралд 1 удаа	50.0	200.0	2024 он	
6	Шингэн хог хаягдал хадгалах зориулалтын цэгтэй болох	Шингэн хог хаягдлын	Тогтмол	Үйл ажиллагааны зардал		2024 он		
7	Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх сургалт хийх	Үйлдвэрийн ажилчдад	удаа	Үйл ажиллагааны зардал		2024 он	Засгийн газрын 116 тогтоол	
8	Үүсэх хог хаягдлын төрөл, кодыг ЗГ-ын 116 тогтоолд заасан хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтоосон байх	Төслөөс үүсэх хог хаягдал	удаа	Үйл ажиллагааны зардал		2024 он		
9	Хатуу үлдэгдлийн нэгдсэн менежмент боловсруулах	Хог хаягдлын нэгдсэн менежмент	Иж бүрэн	1 удаа	1 000.0	1,000.0	2024 он	Хог хаягдлын тухай хууль
<b>Нийт дүн</b>						<b>3,200.0</b>		

БҮЛЭГ 9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл	Ажлын идэвхтэй талбайг тойруулан хангалттай/зохистой гэрэлтүүлж, гэрэл цацруулагч саад тавих	Төслийн талбай	Иж бүрэн	1	Үйл ажиллагааны хүрээнд		2024 он	MNS 5002:2000, “ХААЭА. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага”  MNS ISO 13688:2000, “ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага”  MNS 5390:2004, “ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”
2		Гал гарах зэрэг онцгой нөхцөлд хариу ажиллах бэлэн байдал (журам мөрдөх, ажилчдыг сургах, тоног төхөөрөмж, хэрэгсэл, хангамж),	Төслийн талбай	тогтмол	-	2,000.0		2024 он	
3		Төслийн тухай мэдээллийн самбар, ажил эхлэх, дуусах хугацаа, холбоо барих хаяг, талбайн удирдах ажилтан, ачааны машинуудын явах зам, дэд төслийн зохион байгуулалт зэргийг мэдээлнэ.	Төслийн талбай	Иж бүрэн	1	700.0		2024 он	
4		Цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг графикайн дагуу хийдэг, бүртгэл хөтөлдөг, дотоод хяналтын журам боловсруулж мөрдөх, хяналтын ажилтныг томилон ажлын байрны тодорхойлолтод ажил үүргийн хуваарийг нарийн тусгах	Төслийн талбайн эрүүл ахуйн хамгаалалтын бүс	Тогтмол	1	Үйл ажиллагааны хүрээнд		2024 он	
5		Ажилчид ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл, аюулгүй байдлын дүрмийг хатуу мөрдөх талаар танилцуулна	Ажилчдад	Тогтмол	1	Үйл ажиллагааны хүрээнд		2024 он	
6	Ажилчдын эрүүл мэнд,	Ажиллагсдыг зориулалтын иж бүрэн хувцас хэрэгслээр хангах	Ажилчдад	2 жилд 1 удаа	41 хүн	Үйл ажиллагааны хүрээнд		2024 он	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
7		Ажилчдыг эрүүл мэндийн хугацаат үзлэг, шинжилгээнд хамруулах	Ажилчдад	Жил 1 удаа	41 хүн	Гэрээт ажлын дүнгээр		2024 он	
8		Болзошгүй аюул ослын үед ашиглах бүрэн ажиллагаатай галын хор, багаж хэрэгслүүдийг бүх объектуудад байрлуулах, галын аюулын үед ашиглах ослын гарцын зураглал хийж төвийн доторх хананд байршуулах	Төслийн талбай	Тогтмол		Үйл ажиллагааны хүрээнд		2024 он	
9	Галын аюулгүй байдлыг хангаагүйгээс гал түймрийн осол аварта өртөх	Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах	Төслийн талбай	удаа	Жилд 1	Үйл ажиллагааны хүрээнд		2024 он	Галын аюулгүй байдлын тухай хууль, 1999 он Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 он Хөдөлмөр хамгаалал стандартын систем. Галын аюулгүй

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
11		Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл болох лоом, хүрз, сүх, хөрөө, хувин, хоолой, багор дэгээ, жоотуу, тармуур, хөөс, хорны суурь, тэмдэг тэмдэглээ, сарай, элсний хайрцаг, шланг зэргийг бэлэн байлгах.	Төслийн талбай	Тогтмол		Үйл ажиллагааны хүрээнд		2024 он	байдал ерөнхий шаардлага MNS4244:94
<b>Нийт дүн</b>						<b>2,700.0</b>			

**БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

БОМТ-ний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан мониторингийн цэгээс хөрс, ус, агаарын дээжийг тогтмол хугацаанд авч, итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэж, Байгаль орчны хяналт шинжилгээний тайлангийн үр дүнг жил бүрийн БОМТ-ний биелэлтийн тайланд тусгаж төсөл хэрэгжих сумдын багийн удирдлага болон нөлөөллийн бүсийн иргэдэд нээлттэй мэдээлж байх шаардлагатай.

*Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр*

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Төсөв, мян. төг	Хууль, бодлого, стандарт
<b>Агаарын чанар</b>						
CO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> Тоос нийт (PM10, PM2.5) Дуу шуугиан хэмжээ	- Төслийн талбайн хашаан дотор-3 цэг - 107°30'9.3"E 42°37'37.1"N - 107°30'12.2"E 42°37'33.1"N - 107°30'17.6"E 42°37'37.5"N	Улиралд нэг удаа	3 цэгт	36,000 төг*3 цэг*4 удаа* 1жил	432.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн шаардлага
<b>Хөрс</b>						
Нянгийн шинжилгээ/ Нянгийн ерөнхий тоо, гэдэсний бүлгийн нянгийн тоо, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян, E.Coli халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн тоо/	- Хог хаягдлын цэг-1 цэг - 107°30'13.1"E 42°37'31.3"N	Жилд 1 удаа	1 цэгт	25,000 төг*1удаа* 1жил	25.0	- MNS 3297:2019, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх” - MNS 5850:2019, “Хөрсний чанар, хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
Хөрсний хүнд металлууд (Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr)	- Төслийн талбайн ил гарсан хөрснөөс -2 цэг - 107°30'9.3"E 42°37'36.4"N - 107°30'12.1"E 42°37'33.8"N	Улиралд нэг удаа	2 цэгт	28,000 *2 цэг*4 удаа* 1жил	224.0	
<b>Усны чанар</b>						
Усны ерөнхий хими, Бактериологи	- Унд, ахуйн ус - 107°30'7.7"E 42°37'36.3"N	Улиралд нэг удаа	1 цэгт	75,000 *1 цэг*4 удаа* 1жил	300.0	- MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
<b>Нийт дүн</b>					<b>981.0</b>	

**БҮЛЭГ 11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хугацаа хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			сар	сар	сар		
1	2	3	4	5	6	7	
1	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10 <sup>1</sup> болон БО-ы ерөнхий үнэлгээний шаардлагын дагуу 2 жил тутамд Байгаль орчны аудит хийлгэх	8,800.0	9-р сар			“Урд гурван сайхан” ХХК	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчны аудит хийх эрх олгох журам
2	Ажиллаж байгаа ажиллагсдын тухайн ажлыг хийж гүйцэтгэх мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор мэргэжлийн сургалтад хамруулж байх	ХХАА-ны зардалд тусгасан			9-10 сар	“Урд гурван сайхан” ХХК	МУ-ын үндсэн хууль Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм
3	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод төлөвлөлтөөр		8-р сар		“Урд гурван сайхан” ХХК	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
4	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг АБОЯ-нд хүргүүлж байх, тухайн жилийн БОМТ-г батлуулж байх	ЭАБОАБ-ын хэлтсийн ажил үүргийн хуваарьт оруулж өгөх	Жил бүр		11-12 сар	“Урд гурван сайхан” ХХК	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.12-р заалт, БОАЖ-ын сайдын 2019 оны А/618 тоот тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
5	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Гэрээний үнийн дүнгээр		5-р сар		“Урд гурван сайхан” ХХК	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
<b>Нийт зардал</b>		<b>8,800.0</b>					

## БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ.

Хүснэгт 13. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх арга хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Төрийн захиргааны төв байгууллагад	БОМТ-н жилийн төлөвлөгөө	БОННУ-р тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, зөвлөмж, батлагдсан БОМТ-нд үндэслэн тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах	Жил бүр Эхний улиралд	Төлөвлөгөө батлуулах	АБОГ
Төрийн захиргааны төв байгууллагад	БОМТ-н жилийн тайлан	Төлөвлөгөөний хэрэгжилт, ОХШХ-н хэрэгжилт	Жил бүр 11-р сарын 1-ний дотор	Тайлан хянуулах	АБОГ
АБОЯ-ийн сайдын 2019 оны А/618 тоот тушаалын 4.3-т заасны дагуу ажлын хэсгийг тухайн аймаг, нийслэлийн ЗД-ын захирамжаар байгуулна.	БОМТ-н жилийн төлөвлөгөө, тайлан	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Жил бүр 11-р сарын 30-ний дотор	Тайлан хянуулах, дүгнүүлэх (хяналтын хуудас авах)	Аймаг, ЗД-ын захирамж
<b>Нийт зардал</b>			-		